

СУМЫН ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ

*С. Доржиев* *Э. Энхтэндорж*

2019 оны 5-р сарын 03-ны өдөр



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН БАЯР НААДМЫН  
ТАЛБАЙ БАРИХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖ АХУЙН НЭГЖИЙГ  
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

ӨЛЗИЙТ СУМ

2019 он

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2019.06.03.

**ӨЛЗИЙТ СУМЫН БАЯР НААДМЫН ТАЛБАЙ БАРИХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖ  
АХУЙН НЭГЖИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** Өлзийт сумын баяр наадмын талбай барих ажлыг гүйцэтгэх аж  
ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг

**Төслийн дугаар:** ӨЛЗИЙТ ОНХС 2019/01002

2019.06.03

**Өвөрхангай аймгийн Өлзийт Засаг даргын тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Өлзийт сумын баяр наадмын талбай барих ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50.000** /тавин мянган/ төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[45]** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутанд Өвөрхангай аймгийн Өлзийт Засаг даргын тамгын газарт цахимаар** ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 14 цаг 30 минут** -т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Өвөрхангай аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газар**

Утас: 99329338,86064449

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

| <b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b> | <b>Шалгуур үзүүлэлт</b>   |
|--------------------------------|---|
| <b>ТӨӨЗ 1.1</b>                | <ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 1 жил / 2018/ оны санхүүгийн тайлан /аудитаар баталгаажсан байх/</li> <li>- Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар хураамж, төлбөрөө төлсөн байна. (Тендерийн нээлт хийх өдрийн байдлаар захиалагч Татварын байгууллагаас цахим лавлагаа авна);</li> <li>- Захиалагч татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ;</li> <li>- Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажлын туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээ, акт;</li> <li>- Борлуулалтын орлого сүүлийн 1 жилийн дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй</li> <li>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх ба нотлох баримт ирүүлнэ; Энэ нь тамга тэмдэгээр баталгаажсан байна.</li> <li>- Бусад нэмэлт шаардлага; Харилцагч банкуудын тодорхойлолт, Шүүх, ШШГ Албаны тодорхойлолт, Татвар, НД-ын байгууллагын тодорхойлолт, Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>- Барилгын тусгай зөвшөөрөлтэй байх</li> </ul> |
| <b>ТӨӨЗ 2.1</b>                | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Өвөрхангай аймгийн Өлзийт Засаг даргын тамгын газар</b></p> <p>Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>   |
| <b>ТӨӨЗ 2.1</b>                | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Өвөрхангай аймгийн Өлзийт Засаг даргын тамгын газар</b> “Иргэний танхим”</p> <p>Огноо: <b>2019 оны 06 дугаар сарын 10-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>14цаг 30 минут</b></p>   |
| <b>ТӨӨЗ 6.2</b>                | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй байна.</p>   |

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

| № | Барааны нэр, тодорхойлолт         | Тоо, хэмжээ | Нийлүүлэх хуваарь _____ хойш /, долоо хоног, сараар/ |
|---|-----------------------------------|-------------|--|
| 1 | Өлзийт сумын наадмын талбай барих | 1           | Гэрээ байгуулснаас хойш 25 хоногийн дотор            |
|   |                                   |             |  |

### Техникийн тодорхойлолтын хураангуй.

Хийгдэх бараа болон холбогдох үйлчилгээ нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

#### техникийн тодорхойлолт

| № | Хийх ажлууд           | Талбайн хэмжээ, хийх үзүүлэлт  |
|---|-----------------------|--|
| 1 | Наадмын талбайн хашаа | Наадмын талбайн хашааг 160 метр урттай хэмжээгээр 1,2 метр өндөртэй гагнаж хийнэ. Шон хоорондын зай 2 метр байна.  |
| 2 | Хашааны хаалга        | Наадмын талбайн 1 талд 3 м өргөнтэй 1 том хаалга, 2 жижиг хаалгыг 1,6метрээс доошгүй өндөртэй, сараалж төмөр хоорондын зайг 10см-ээс ихгүй байхаар, баганатай, загвар дизайн сайтайгаар хийнэ. |
| 3 | Төв асар              | 6 метр урттай, 3 метр өндөртэй голын асарыг техникийн тодорхойлолт, зураг, хэмжээний дагуу хийж, 20см өндөртэй / 6*3 / хэмжээтэй бетонон суурь шал зутгана.                                    |
| 4 | Төв асар              | Голын ба захын 2 асарын үндсэн рамыг 4мм-ээс доошгүй зузаантай, 60*60 квадратаар, захын даац өгөх баганауудыг 80*80 квадратаар гагнаж хийнэ.   |
| 5 | Төв асар              | Будаг ..... өнгөөр будна.  |
| 6 | Төв асар              | Дээврийн хэсгийг 10мм-ийн OSPO хавтангаар хийж 0,9 мм-ээс дээш зузаан төмрөөр дээвэрлэнэ.  |
| 7 | Төв асар              | Шонгууд болон дээврийн, холбоосыг чанартай гагнаж холбоно. Хавтан хоорондын дээврийн   |

|    |                               |   |
|----|-------------------------------|---|
|    |                               | хөндлөн холбоосыг зохих стандартын дагуу хийнэ.   |
| 8  | Төв асар                      | 2 талын 4 метр урттай, 3 метрийн өндөртэй, 3 метрийн өргөнтэй 2 асарыг техникийн тодорхойлолт, зураг, хэмжээний дагуу хийж, 10 см өндөртэй /4*3/ хэмжээтэй бетонон суурь шал цутгана. |
| 9  | Төв асар                      | Сандал, тавцангуудыг техникийн тодорхойлолт, зурагт заагдсан хэмжээний дагуу 2 эгнээ марштай хийнэ. / төмөр, модон хийцээр /  |
| 10 | Урд асар                      | 15 метр урттай, 2,5 метр өндөртэй, 3 метрийн өргөнтэй байна. үндсэн рамгыг 4мм-ээс доошгүй зузаантай, 60*60 квадратаар, захын даац өгөх баганауудыг 80*80 квадратаар хийнэ.           |
| 11 | Урд асар                      | Дээврийн хэсгийг 10мм-ийн OSPO хавтангаар хийж 0,9 мм-ээс дээш зузаан төмрөөр дээвэрлэнэ.   |
| 12 | Урд асар                      | Будгыг .....өнгөөр будна.   |
| 13 | Урд асар                      | Шонгууд болон дээврийн холбоосыг чанартай гагнаж холбоно. Хавтан хоорондын дээврийн хөндлөн холбоосыг зохих стандартын дагуу хийнэ.   |
| 14 | Урд асар                      | Багана хоорондын зай 1.2 м байна.   |
| 15 | Сандлын тавцан                | 2 эгнээ марштай 3 см-ээс доошгүй зузаантай хатаасан банзаар 40 см өргөнтэй хийнэ.   |
| 16 | Сандлын тавцан                | Будгыг .....өнгөөр будна.   |
| 17 | Зүүн баруун талд сандал нэмэх | Нэг бүр нь 4.5м урттай, 2 эгнээ марштай түшлэгтэй сандал 8 ширхэгийг хийж 2 талд хувааж суурилуулна.  |
| 18 | Ерөнхий шаардлага             | 6 ширхэг хогийн сав байрлуулна.   |
| 19 | Ерөнхий шаардлага             | 9-н хөлт цагаан тугны суурь хийнэ   |
| 20 | Ерөнхий шаардлага             | 3-н далбаа мандаж байх суурь хийнэ.   |
| 21 | Ажиллах хүч                   | Нийт ажилчдын 40 хувиас доошгүйг сум орон нутгийн иргэдээс ажиллуулна.  |



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Хийгдэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл          | Тодорхойлолт | Хийгдэх ажлын гарал үүсэл дотоод зах зээлээс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|--|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1                  | 2            | 3  | 4          | 5        | 6        | 7                             | 8        |
|                    |              |  |            |          |          |                               |          |
|                    |              |  |            |          |          |                               |          |
| Тендерийн нийт үнэ |              |  |            |          |          |                               |          |

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

| Гэрээний нэр | Захиалагч,<br>холбоо<br>барих<br>хаяг/утас/фа<br>кс | Гэрээний<br>үнийн дүн | Гэрээний<br>эхлэх хугацаа | Гэрээний<br>дуусах<br>хугацаа |
|--------------|---|-----------------------|---------------------------|-------------------------------|
| 1.           |   |                       |                           |                               |
| 2.           |   |                       |                           |                               |
| 3.           |   |                       |                           |                               |
| 4.           |   |                       |                           |                               |
| 5.           |   |                       |                           |                               |
| бусад.       |   |                       |                           |                               |

**Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |

- 10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

| ЗАХИАЛАГЧ       | НИЙЛҮҮЛЭГЧ      |
|-----------------|-----------------|
| _____           | _____           |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____           | _____           |
| (Гарын үсэг)    | (Гарын үсэг)    |
| _____           | _____           |
| (Албан тушаал)  | (Албан тушаал)  |

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....  
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*



